



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 9 сарын 25 өдөр

Дугаар А/263

Мандалговь

Ажлын хэсэг байгуулж, дэмжлэг
үзүүлэх тухай

Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/492 дугаар захирамжаар батлагдсан Ахмад настны талаар 2018-2021 онд баримтлах бодлогын 5.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Аймгийн ахмадын спортын 2 дугаар наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн дарга: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: М.Наранбадрах(Биеийн тамир спортын газрын дарга)

Гишүүдэд: Р.Лхагвадорж (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Сугир (Аймгийн ахмадын хорооны дарга)

С.Цолмон (Биеийн тамир спортын газрын мэргэжилтэн)

Д.Доржсүрэн (Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга)

Ц.Загдсүрэн (Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)

Хоёр.Аймгийн ахмадын спортын 2 дугаар наадмын удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

482010732

Гурав. Аймгийн ахмадын спортын 2 дугаар наадмыг 2020 оны 10 дугаар сарын 20-21-ны өдрүүдэд удирдамжийн дагуу бэлтгэл зохион байгуулалттай явуулж, үр дүнг 10 дугаар сарын 25-ны дотор багтаан тайлагнахыг ажлын хэсгийн дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Аймгийн ахмадын спортын 2 дугаар наадмыг зохион байгуулах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

Тав. Аймгийн ахмадын спортын 2 дугаар наадамд зарцуулагдах 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн) , нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2020 оны 04 сарын 25 өдрийн
А/263 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН АХМАДЫН СПОРТЫН 2 ДУГААР БАГА НААДМЫН УДИРДАМЖ

Нэг. Тэмцээний зорилго

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ахмад настны эрүүл насжилтыг дэмжиж, тэдний чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамир спортыг олон түмэнд сурталчилж, ахмад тамирчдыг харилцан туршлага солилцуулах, хүүхэд залууст үлгэр дууриал үзүүлэхэд оршино.

Хоёр. Тэмцээний удирдлага, зохион байгуулалт

Тэмцээнийг Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг, томилогдсон шүүгчид зохион байгуулан явуулна.

Тэмцээнд эрэгтэй 60, эмэгтэй 55 түүнээс дээш настай ахмад тамирчид оролцоно. Нэг сумаас ирсэн ахмад тамирчдыг нэг баг гэж үзнэ.

Сумын ахмадын хороод өөрийн сумын туг, бэлэгдэл, тамирчид тоглолтын хувцсаар жигдэрч, лого тэмдэгээ зүүж, медальтай тамирчид медальтайгаа жагсана.

Сумын ахмадын хороод оролцох тамирчдынхаа мэдүүлгийг 2020 оны 10-р сарын 19-ний өдөр багтаж аймгийн ахмадын хороонд өгсөн байна.

Сумын ахмадын хороо бүр оролцох эрхийн төлбөрт 40000 төгрөг төлнө.

Тамирчид иргэний үнэмлэхээрээ мандат авна. Мандатын үнэ 3000 төгрөг. Мандатыг мэдүүлгийн дагуу нэгдсэн журмаар аймгийн ахмадын хороон дээр олгоно.

Сумын ахмадын хороод байр хоол, унааны зардлаа өөрсдөө хариуцна.

Гурав. Хугацаа

Тэмцээнийг 2020 оны 10-р сарын 20-21 -ны өдрүүдэд Мандалговь хотод зохион байгуулна.

Техникийн зөвлөгөөнийг 2020 оны 10-р сарын 19.-ны 17 цагаас аймгийн ЗДТГ-ын их танхимд шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр хийнэ. Тэмцээн явагдах байр танхим, талбайг техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.

Тэмцээн 2020 оны 10-р сарын 20-ний өдрийн өглөөний 10 цагаас аймгийн БТСГ-ын спорт зааланд наадмын нээлтийн жагсаалаар эхлэнэ.

Дөрөв. Тэмцээний төрөл

Тэмцээн спортын дараах төрлүүдээр явагдана.

1. Софть волейбол /эрэгтэй 4, эмэгтэй 4/ холимог баг
 2. Шатар - Эрэгтэй 1, эмэгтэй 1,
 3. Ширээний теннис- Эрэгтэй 1, эмэгтэй 1,
 4. Шагайн харваа - Хуруу, чавхаар тус бүр 1 тамирчин
 5. Гранди гольф - эрэгтэй 1.эмэгтэй 1
 6. Цэнгээнт бүжиг - эрэгтэй 2, эмэгтэй 2 тамирчин оролцоно.
- Нэг тамирчин спортын 2 төрөлд оролцож болно.

Тав. Тэмцээнийг дүгнэх журам, олгох шагнал

Софть волейбол, шатар, ширээний теннис, шагайн харваа,гранди гольф,цэнгээнт бүжиг .тэмцээн тус бүрээр 1-3 байр эзлүүлж байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаана.

Тэмцээний төрөл бүрээр хожлын онооны байдлаар цуваагаар байр эзлүүлж нийт дүнг гаргаж, сумын ахмадын хороодыг байр эзлүүлнэ.

Зургаа: Багийн дүнгээр олгох шагнал

Тэргүүн байр – 1.Шилжин явах цом, Өргөмжлөл 700.0 мян төгрөг

Дэд байр – 1.Өргөмжлөл 500.0 мян төгрөг

Гутгаар байр – 1.Өргөмжлөл 300.0 мян төгрөгөөр тус тус шагнаана.

ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 25 өдрийн
 А/263 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

АЙМГИЙН АХМАДЫН СПОРТЫН НААДМЫН ТӨСӨВ

д/д	Арга хэмжээний төрөл		Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
а/Спортын төрлөөр					
1	Шатар	1 дүгээр байр	2	20000	40000
		2 дугаар байр	2	15000	30000
		3 дугаар байр	2	10000	20000
2	Ширээний теннис	1 дүгээр байр	2	20000	40000
		2 дугаар байр	2	15000	30000
		3 дугаар байр	2	10000	20000
3	Шагайн харваа	1 дүгээр байр	2	20000	40000
		2 дугаар байр	2	15000	30000
		3 дугаар байр	2	10000	20000
4	Граунд гольф	1 дүгээр байр	2	20000	40000
		2 дугаар байр	2	15000	30000
		3 дугаар байр	2	10000	20000
5	Софты волейбол	1 дүгээр байр	8	20000	160000
		2 дугаар байр	8	15000	120000
		3 дугаар байр	8	10000	80000
6	Цэнгээнт бүжиг	1 дүгээр байр	4	20000	80000
		2 дугаар байр	4	15000	60000
		3 дугаар байр	4	10000	40000
6	Цом		1	50000	50000
7	Өргөмжлөл	3 суманд	3	34000	102000
8	Сумдын шагнал	1 дүгээр байр			700000
		2 дугаар байр			500000
		3 дугаар байр			300000
9	Шүүгчийн хөлс	2 өдөр	12	25000	600000
	Сургагч багш нарын				350000
10	Медаль		60	6500	390000
11	Жааз		37	3000	111000
12	Өргөмжлөл-А-5		60	1000	60000
13	Анонс 4*3		12	7000	84000
14	Анонс 5*4		20	7000	140000
15	Мандат		300	250	75000
16	Мандатны уут		300	500	150000
Зарлагын дүн					4512000
б/ орлого					4512000
д/д Санхүүжих эх үүсвэр					4512000
1	Аймгийн Засаг даргын нөөц сангаас				1500000
2	Сумдын ахмадын хорооноос оролцох эрхийн төлбөрт				600000
3	Мандатны үнэ /1 сумаас 15 хүн*15 аймаг*3.0 мян/төг/				675000
4	Бүжгийн орлого				300000
5	Аймгийн Ахмадын хороо				1437000
Орлогын нийт дүн					4512000

АЙМГИЙН АХМАДЫН ХОРОО